

ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТ

ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ТАЙЛАН



**Судалгаа Статистикийн газар,
Судалгааны хэлтэс**

Энэхүү тайланд зөвхөн түүвэр судалгаанд хамрагдсан иргэд, аж ахуй нэгж болон шинжээчдийн эдийн засгийн төлөө байдлын талаарх хүлээлтийн үр дүнг нэгтгэн тайлагнасан учир Монголбанкны албан ёсны байр суурь биш болно.



ИРГЭДИЙН ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТ

1-Р БҮЛЭГ



ТҮҮВЭР СУДАЛГАА
2018 ОНЫ I УЛИРАЛ

1. Иргэдийн Инфляцийн Хүлээлт

Инфляцийн талаарх иргэдийн хүлээлтийн түүвэр судалгааг Дэлхийн банкны “САР” системд суурилан 2018 оны 2 дугаар сарын 23-ны өдрөөс 3 дугаар сарын 1-ний өдрүүдэд Улаанбаатар хотын 7 дүүргийн 825 иргэнийг санамсаргүй түүврийн аргаар сонгон судалгааг гүйцэтгэлээ. Түүвэр судалгаанаас дараах гол үр дүнгүүд гарлаа:

- Иргэд инфляцийн түвшинг i) чанарын хариултын хувьд 2018 оны II улиралд 10.9%, 2019 оны I улиралд 10.2% байхаар; ii) тоон хариултын хувьд 2018 оны II улиралд 5.4%, 2019 оны I улиралд 6% байхаар; iii) мэдрэмж (үнийн дарамтыг мэдэрч буй байдал)-д суурилсан инфляцийн хүлээлтийн хувьд 2018 оны II улиралд 4.5%, 2019 оны I улиралд 6.4% байхаар тус тус хүлээж байна;
- Иргэдийн хувьд зээлийн хүү ирээдүйд бага зэрэг өснө гэж хүлээж байна;
- Иргэд эдийн засгийн байдал сайжирч, өрхийн санхүүгийн байдал сайжирна гэсэн зэрэг хүлээлттэй байна;
- Иргэд төгрөгийн ханш чангарна гэсэн хүлээлттэй байна.

1.1. Инфляцийн хүлээлт


Чиглэлийн индексээс харахад 2017 оны эхэн үеэс иргэдийн үнийн өсөлтийн талаарх хүлээлт хандлагаараа аажмаар өсч ирсэн байна. Энэ удаагийн судалгааны үр дүнг 2017 оны IV улирлын дүнтэй харьцуулахад үнийн өсөлтийн талаарх иргэдийн хүлээлт бага зэрэг өсчээ. Өөрөөр хэлбэл иргэдийн дунд инфляци өнөөдрийн түвшнээс бага зэрэг өснө гэсэн хандлага давамгайлж байна /Зураг 1-1/.

Зураг 1- 1. Үнийн өсөлтийн талаарх хандлага /чиглэлийн индекс, ирэх 12 сар/



Эх сурвалж: Монголбанк, иргэдийн хүлээлтийн түүвэр судалгаа

Зураг 1- 2. Иргэдийн инфляцийн хүлээлт /чанарын болон тоон хариултаар/



Эх сурвалж: Монголбанк, иргэдийн хүлээлтийн түүвэр судалгаа


Иргэдийн инфляцийн хүлээлтийг олон улсын туршлагад тулгуурлан тоон болон чанарын аргачлалаар тооцлоо. Чанарын хариултыг Карлсон-Паркины аргачлалд тулгуурлан тоон үзүүлэлт рүү шилжүүлж тооцоход иргэд инфляцийг 2018 оны II улиралд 10.9%, 2019 оны I улиралд 10.2% байхаар хүлээж байна. Мөн иргэдийн инфляцийн хүлээлтийг тоон хариултад тулгуурлан тооцоход 2018 оны II улиралд 5.4%, 2019 оны I улиралд 6%-тай байна. Түүнчлэн өнгөрсөн үеийн мэдрэмжид суурилсан инфляцийн түвшин */perceived inflation/*² 2018 оны II улиралд 4.5%, 2019 оны I улиралд 6.4%-тай байхаар хүлээгдэж байна */Зураг 1-2/*.

Хүлээлтийн чанарын хариултаас харвал иргэдийн 75% нь ирэх 12 сард үнийн түвшин ерөнхийдөө өснө гэж үзсэн бөгөөд үүнээс 28% нь үнийн түвшин илүү хурдацтайгаар өснө (өмнөх судалгааны дүнгүүдээс өссөн), 29% нь үнэ өснө гэхдээ өсөлтийн хурдац өөрчлөгдөхгүй гэж хариулжээ */Зураг 1-3/*.


Иргэдийн инфляцийн хүлээлтийг тоон утгаар асууж, хариултуудын жигнэсэн дундаж утгыг тооцон үзэхэд инфляцийг ирэх улиралд буюу 2018 оны I улиралд 5.4%, жилийн дараа буюу 2019 оны II улиралд 6.0%-тай байхаар хүлээж байна. Өөрөөр хэлбэл иргэдийн дунд ирэх 12 сарын хугацаанд үнийн түвшин өснө гэсэн хүлээлт давамгайлж байна */Зураг 1-4/*.

Харин жилийн дараа инфляци 6-8% байна гэсэн хариултыг иргэд хамгийн их давталттай өглөө.

Зураг 1-3. Ирэх 12 сарын хугацаанд үнийн түвшин хэрхэн өөрчлөгдөх вэ?



Зураг 1-4. Иргэдийн инфляцийн хүлээлтийн тархалт /тоон хариултаар/




Эх сурвалж : Монголбанк, иргэдийн хүлээлтийн түүвэр судалгаа

²-Монголбанкны Судалгааны Товхимол-7. “Инфляцийн хүлээлтийг тооцох арга, аргачлалыг өргөжүүлэх нь” сэдэвт судалгааны ажлаас дэлгэрэнгүйг харна уу.


Иргэд 2018 оны IV улирлын хүнсний бус бүтээгдэхүүний инфляцийг 6.0%, хүнсний бүтээгдэхүүний инфляцийг 6.1%-тай байхаар хүлээж байна /Зураг 1-5/. Хариултын тархалтаас харахад дараа жилийн хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт 6-8% байх хариулт хамгийн олон давталттай байна.

Судалгаанд хамрагдсан иргэдийн 80% нь 2018 оны II улиралд инфляцийн түвшинг зорилтот түвшинд буюу 8%-аас бага байна гэж үзсэн /Зураг 1-6/.

Зураг 1- 5. Инфляцийн хүлээлтийн тархалт /хүнсний, хүнсний бус, ирэх 12 сар/



Зураг 1- 6. Инфляцийн хүлээлтийн хуримтлагдсан тархалт /тоон хариултаар/



Эх сурвалж : Монголбанк,иргэдийн хүлээлтийн түүвэр судалгаа

1.2. Эдийн засгийн өсөлт, иргэдийн орлого

Эдийн засгийн чиглэлийн индекс өмнөх улирлын судалгааны дүнгээс бага зэрэг өссөн дүнтэй буюу судалгаанд хамрагдсан иргэдийн дийлэнх нь ирэх 12 сарын хугацаанд эдийн засгийн байдал сайжрах төлөв ажиглагдана гэсэн эерэг хүлээлттэй хэвээр байна /Зураг 1-7/.

Энэ удаагийн иргэдийн өрхийн санхүүгийн байдлын чиглэлийн индексээс харахад иргэдийн дийлэнхи нь ирэх 12 сарын хугацаанд өрхийн санхүүгийн байдал сайжирна гэсэн хүлээлттэй байна /Зураг 1-8/.


Иргэд ирэх нэг жилийн хугацаанд эдийн засгийн ерөнхий байдал сайжрахын хирээр өрхийн санхүүгийн байдалд эерэг нөлөө үзүүлнэ гэсэн хүлээлттэй байна.

1.3. Валютын ханшийн хүлээлт

Ханшийн хүлээлтийн чиглэлийн индексээс харахад 2017 оны I улирлаас эхлэн иргэдийн хувьд төгрөгийн ханш чангарна гэсэн хүлээлт нэмэгдсэн, улмаар 2018 оны I улиралд явуулсан судалгаагаар иргэдийн дунд төгрөгийн ханш чангарна гэсэн хүлээлт өндөр хэвээр байна /Зураг 1-9/.

Гэвч 2017 оны III, IV улиралд явуулсан судалгаатай харьцуулахад ханшийн хүлээлтийн индекс бага зэрэг өссөн буюу чангарна гэсэн хандлага харьцангуй буурч байна.

Зураг 1- 7. Ирэх 12 сарын эдийн засгийн төлөвийн талаарх хүлээлт /ирэх 12 сард/




Зураг 1- 8. Өрхийн санхүүгийн талаарх хүлээлт /ирэх 12 сард/



Тайлбар: Чиглэлийн индекс [-1;1] завсарт утгаа авна. [0;1] эдийн засгийн байдал сайжирна, [0] хэвэндээ байна, [0;-1] муудна.

Зураг 1- 9. Ирэх 12 сарын хугацаанд валютын ханшийн талаарх хүлээлт




Эх сурвалж: Монголбанк, иргэдийн инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа

1.4. Хүүний түвшний ирээдүйн хандлага


Судалгаанд хамрагдсан иргэдийн хувьд ирэх 12 сарын хугацаанд хадгаламж болон зээлийн хүү өндөр хэвээр байна гэсэн хүлээлттэй байна /Зураг 1-10, Зураг 1-12/.

Санал асуулгад оролцсон иргэдийн 27% нь ирэх 12 сарын хугацаанд хадгаламжийн хүү өснө гэж үзсэн бол 54% нь хэвэндээ, 18% нь хадгаламжийн хүү буурна гэж хариулжээ /Зураг 1-11/.


Зураг 1-10. Зээлийн хүүний талаарх хүлээлт /ирэх 12 сард/



Зураг 1-11. Хадгаламжийн хүүний талаарх хүлээлт /ирэх 12 сард/



Зураг 1-12. Хадгаламжийн хүүний талаарх хүлээлт /ирэх 12 сард/



Эх сурвалж : Монголбанк,иргэдийн хүлээлтийн түүвэр судалгаа

АЖ АХУЙ НЭГЖИЙН ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТ

2-Р БҮЛЭГ



ТҮҮВЭР СУДАЛГАА
2018 ОНЫ I УЛИРАЛ

2. Аж Ахуй Нэгжийн Инфляцийн Хүлээлт

ААН-ийн хүлээлтийн түүвэр судалгааг Дэлхийн банкны “САР” системд суурилан 2018 оны 3 дугаар сарын 2-ны өдрөөс 6-ны өдрүүдэд Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй 383 бизнес эрхлэгчдээс санамсаргүй түүврийн аргаар сонгон судалгааг гүйцэтгэлээ. Түүвэр судалгаанаас дараах гол үр дүнгүүд гарлаа:

- ААН-үүд инфляцийн түвшинг i) чанарын хариултын хувьд 2018 оны II улиралд 4.5%, 2019 оны I улиралд 5.1%; ii) тоон хариултын хувьд 2018 оны II улиралд 5.9%, 2019 оны I улиралд 6.2%; iii) мэдрэмж (үнийн өсөлтийн дарамт мэдрэгдэж буй байдал)-д суурилсан инфляцийн хүлээлтийн хувьд 2018 оны II улиралд 5.2%, 2019 оны I улиралд 5.9% байхаар тус тус хүлээж байна;
- ААН-үүдийн дунд төгрөгийн ханш чангарна гэсэн хүлээлт давамгайлж байна. Энэ нь төгрөгт итгэх итгэл өндөр байгааг илтгэж байна;
- ААН-үүд ирэх 6 сарын хугацаанд нийт эрэлт нэмэгдэж, борлуулалтын орлого өснө гэж хүлээж байгаа бөгөөд цалингийн түвшин ч мөн бага зэрэг өснө гэж хүлээж байна;
- Түүвэрт хамрагдсан ААН-үүдийн 30 орчим хувь нь үйл ажиллагаагаа өргөжүүлж, шинээр ажлын байр нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна;

2.1. Инфляцийн хүлээлт

Инфляцийн хүлээлтийн талаарх чиглэлийн индексээс харахад сүүлийн 3 улиралд инфляцийн хүлээлт бага зэрэг өсч, тогтворжино гэсэн мужид хадгалагдаж байгаа нь ААН-үүд инфляцийг одоогийн түвшинд хадгалагдана гэж үзэж байгааг илтгэнэ /Зураг 2.1/.

Зураг 2-1. ААН-ийн үнийн өсөлтийн хүлээлт /чиглэлийн индекс, 12 сарын дараа/



Зураг 2-2. ААН-ийн инфляцийн хүлээлт /чанар ба тоон хариултаар/



Эх сурвалж: Монголбанк, ААН-ийн хүлээлтийн түүвэр судалгаа

¹-Өснө, буурна гэсэн хариултуудын зөрүүгээр чиглэлийн индексийг (тэнцлийн статистик) тооцно. Ингэхдээ ААН-үүдээс ирэх 12 сард үнийн өсөлт ямар байх талаар асууж, хариултуудыг [3;-1] байхаар нормчилж чиглэлийн индексийг тооцсон.

Аж ахуйн нэгжийн хүлээлтийг олон улсын туршлагад тулгуурлан тоон болон чанарын аргачлалаар тооцлоо. Чанарын хариултыг Карлсон-Паркины аргачлалд тулгуурлан тоон үзүүлэлт рүү шилжүүлж тооцоход ААН-үүд инфляцийг 2018 оны II улиралд 4.5%, 2019 оны I улиралд 5.1%-тай байхаар хүлээж байна.

ААН-ийн инфляцийн хүлээлтийг тоон утгаар асууж, хариултуудын жигнэсэн дундаж утгыг тооцон үзэхэд инфляцийг ирэх улиралд 5.9%, жилийн дараа буюу 2019 оны I улиралд 6.2%-тай байхаар хүлээж байна. Ирэх оны **инфляцийг 6-8 хувьд байна** гэсэн хариулт хамгийн өндөр давтамжтай байна /Зураг 2.3/. Түүнчлэн өнгөрсөн үеийн мэдрэмжид суурилсан инфляцийн түвшин /*perceived inflation*² 2018 оны II улиралд 5.2%, 2019 оны I улиралд 5.9%-тай байхаар хүлээж байна /Зураг 2.2/.


Судалгаанд хамрагдсан ААН-ийн 79% нь 2018 оны II улиралд инфляцийн түвшинг зорилтот түвшинд буюу 8%-аас бага байна гэж үзсэн бол 2019 оны I улиралд ААН-ийн 73% нь инфляци зорилтот түвшнээс бага түвшинд байна гэж хүлээжээ /Зураг 2.4/.

2.2. Валютын ханш, зээлийн хүүний хүлээлт


Ханшийн чиглэлийн индекс 2012 оноос хойш хандлагаараа буурч ирсэн буюу ААН-үүдийн дунд ирэх 12 сарын хугацаанд төгрөгийн гадаад валюттай харьцах ханш өнөөдрийн түвшнээс чангарна гэх хүлээлт давамгайлах болсон байна. Энэ нь ААН-үүдийн төгрөгт итгэх итгэл хэвээр байгааг илтгэнэ. Харин энэ улирал чиглэлийн индекс өмнөх улиралтай харьцуулахад бага зэрэг өссөн байна /Зураг 2.5/.

²-Монголбанкны Судалгааны Товхимол-7. “Инфляцийн хүлээлтийг тооцох арга, аргачлалыг өргөжүүлэх нь” сэдэвт судалгааны ажлаас дэлгэрэнгүйг харна уу.

Зураг 2-3. ААН-ийн инфляцийн хүлээлт /тархалт, тоон хариултаар/



Зураг 2-4. ААН-ийн инфляцийн хүлээлт /хуримтлагдсан тархалт, тоон хариултаар/



Зураг 2-5. Ирэх 12 сарын хугацаан дахь валютын ханшийн хүлээлт



Эх сурвалж: Монголбанк, ААН-ийн хүлээлтийн түүвэр судалгаа



Өмнөх улиралд зээлийн хүүний чиглэлийн индекс анх удаа зээлийн хүү буурна гэсэн утгатай гарсан байсан бол энэ улиралд ААН-үүдийн дунд зээлийн хүү ирэх 12 сарын хугацаанд өснө гэсэн хүлээлт давамгайлж байна /Зураг 2.6/.

2.3. Аж ахуй нэгжийн үйл ажиллагаа

ААН-үүд өнгөрсөн 6 сарын хугацаанд бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт харьцангуй тогтвортой байсан гэж үзжээ. Харин ирэх 6 сарын хугацаанд бизнес эрхлэгчид борлуулж буй барааны эрэлт нь нэмэгдэнэ гэсэн хүлээлттэй байна /Зураг 2.7/.

Эдийн засгийн хүндрэлээс гарч, бизнесийн идэвхжил бага зэрэг нэмэгдсэнээр ААН-үүдийн хувьд үйл ажиллагаагаа тэлэх орон зай үүсч, улмаар ААН-үүд ирэх 6 сарын хугацаанд ажлын байрыг бага зэрэг нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй болжээ. Мөн цалинг ирэх 6 сарын хугацаанд бага зэрэг нэмэгдэнэ гэж хүлээж байна /Зураг 2.8/.


Судалгаанд оролцогч бизнес эрхлэгчдийн 33% нь ирэх 6 сарын хугацаанд үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд дийлэнх ААН банкны зээлээр (35%) болон өөрийн хөрөнгөөр (31%) санхүүжүүлнэ гэж хариулсан /Хавсралт 1-3/.

Тайлбар: Индекс [-1;1] завсарт утгаа авна. [0;1] өснө, [0] өөрчлөгдөхгүй, [0;-1] буурна.

Зураг 2-6. Ирэх 12 сарын хугацаанд зээлийн хүүний хүлээлт



Зураг 2-7. Бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт /өнгөрсөн 6 сар болон ирэх 6 сард/



Зураг 2-8. Ирэх 6 сарын хугацаанд ажлын байр болон цалингаа нэмэгдүүлэх эсэх



Эх сурвалж: Монголбанк, ААН-ийн хүлээлтийн түүвэр судалгаа



ШИНЖЭЭЧДИЙН ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТ

3-Р БҮЛЭГ



ТҮҮВЭР СУДАЛГАА
2018 ОНЫ I УЛИРАЛ

3. Шинжээчдийн Инфляцийн Хүлээлт

Шинжээчдийн инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаанд арилжааны банкууд болон их дээд сургуулиудын судлаач, багш нарыг хамрууллаа. Шинжээчдийн хүлээлтийн түүвэр судалгаанд эдийн засгийн чиглэлээр мэргэшсэн нийт 19 судлаачдын инфляци, эдийн засгийн өсөлт, валютын ханш, бодлогын хүү болон зээлийн хүүний ирэх 12 сарын таамаглалыг нэгтгэн тооцлоо. Судалгааны үр дүн дараах байдлаар харагдаж байна /Хүснэгт 1/.

3.1. Инфляцийн хүлээлт

Шинжээчид инфляцийн түвшинг 2018 оны II улиралд 6.1%, 2018 оны эцэст 7.8% байхаар таамаглаж байгаа нь зорилтот түвшний ойролцоо үзүүлэлт юм. Инфляцийн түвшинг 2018 оны II улиралд хамгийн ихдээ 9.6%, 2018 оны эцэст хамгийн ихдээ 11.9%-д хүрнэ гэж хүлээж байна /Зураг 3-1/.

Инфляцийн таамаглалыг харьцангуй давтамжаар нь авч үзвэл шинжээчдийн дунд инфляци 2018 оны эцэст 7.7%-8.4%-д байна гэсэн хүлээлт давамгайлж байна. Энэ нь судлаачдын дунд ирэх онд инфляцийн түвшин өнөөгийн түвшнээс бага зэрэг өсч, зорилтот түвшний ойролцоо байна гэсэн хүлээлт давамгайлж байгааг илэрхийлж байна /Зураг 3-2/.


Хүснэгт 1. Судалгааны товч үр дүн

Инфляцийн таамаглал	
Цаашид өсч оны эцэст дунджаар 7.8%	[3.5%-11.9%]-ийн интервалд байна гэж таамагласан.
Төгрөгийн ам.доллартай харьцах ханш	
Төгрөгийн ханш чангарна гэж хүлээж байна.	Ирэх онд [2350₮-2550₮]-ийн интервалд таамагласан.
Мөнгөний бодлого, зээлийн хүү	
Бодлогын хүү буурна	Зээлийн хүү буурна гэсэн хүлээлттэй байна.
Эдийн засгийн өсөлт	
Эдийн засгийн өсөлт оны эцэст 5.4%-тай байна гэж таамаглаж байна.	

Зураг 3-1. Инфляци /таамаглал/



Зураг 3-2. Инфляцийн таамаглалын гистограмм /2018 оны эцэст/



Эх сурвалж: Монголбанк, шинжээчдийн хүлээлтийн түүвэр судалгаа

Шинжээчид 2018 оны II улиралд төгрөгийн ам.доллартай харьцах ханшийг чангарах буюу дунджаар 2,400 төгрөг, 2018 оны эцэст мөн л өнөөгийн түвшнээс чангарах буюу 2,389 төгрөгийн орчимд байхаар хүлээж байна. Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийг шинжээчид 2018 оны эцэст хамгийн ихдээ 2,550 төгрөг, харин хамгийн багадаа 2,436 төгрөгт хүрнэ гэж хүлээж байна.

2017 оны IV улиралд шинжээчид ханшийг 2018 оны эцэст 2,419 байхаар таамаглаж байснаас энэ удаагийн таамаглал буурсан буюу төгрөг чангарна гэсэн хүлээлт шинжээчдийн дунд нэмэгджээ /Зураг 3-3/.

Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн дамвтамжийг авч үзвэл ханш 2018 оны эцэст 2350₮-2,420₮ байна гэж дийлэнх судлаачид үзэж байна /Зураг 3-4/.


Шинжээчид бодит ДНБ-ий өсөлтийг энэ оны эцэст 5.4%-д хүрнэ гэж хүлээж байна. Харин зарим шинжээчид 2018 оны эцэст эдийн засгийн өсөлтийг 7.0%-д хүрнэ гэсэн хүлээлттэй байна. 2017 оны IV улиралд шинжээчид бодит ДНБ-ийн өсөлтийг оны эцэст 5.1%-д хүрнэ гэж таамаглаж байсантай харьцуулахад хүлээлт бага зэрэг нэмэгджээ /Зураг 3-5/.

Судлаачдын бодит ДНБ-ий өсөлтийн дамвтамжийг авч үзвэл 2018 оны эцэст бодит ДНБ-ий өсөлт 5%-8.5% байна гэж нийт судлаачдын дийлэнх хувь нь хүлээж байна /Зураг 3-6/.


Зураг 3-3. Ханш /таамаглал/




Зураг 3-4. Ханшийн таамаглалын гистограмм /2018 оны эцэст/



Зураг 3-5. Бодит ДНБ-ий өсөлт /таамаглал/



Зураг 3-6. Бодит ДНБ-ий өсөлт гистограмм /таамаглал, 2018 оны эцэст/



Эх сурвалж: Монголбанк, шинжээчдийн хүлээлтийн түүвэр судалгаа


Шинжээчид бодлогын хүү өнөөгийн түвшнээс буурч 2018 оны эцэст 10 орчим хувьд хүрнэ гэсэн хүлээлттэй байна /Зураг 3-7/.

Бодлогын хүүний хүлээлтийн харьцангуй давтамжийг харахад 2018 оны эцэст бодлогын хүү 10%-11% байна гэсэн хүлээлт хамгийн өндөр байна /Зураг 3-8/.


Тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж хүүг шинжээчид энэ оны эцэст өнөөгийн түвшнээс буурч дунджаар 18.8%-ийн орчимд байна гэж хүлээж байна. Шинжээчид тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж хүүг 2018 оны эцэст хамгийн ихдээ 20.0%, хамгийн багадаа 18.0%-тай байна гэсэн хүлээлттэй байна /Зураг 3-9/.

Шинжээчдийн дийлэнх нь оны эцэст зээлийн хүү 18%-19% байна гэсэн хүлээлттэй байна /Зураг 3-10/.


Зураг 3-7. Бодлогын хүү /таамаглал/




Зураг 3-8. Бодлогын хүүний гистограмм /таамаглал, 2018 оны эцэс/



Зураг 3-9. Зээлийн хүү /таамаглал/



Зураг 3-10. Зээлийн хүүний гистограмм /таамаглал, 2018 оны эцэс/



Эх сурвалж: Монголбанк, шинжээчдийн хүлээлтийн түүвэр судалгаа

ДҮГНЭЛТ, ХАВСРАЛТ

4-Р БҮЛЭГ



ТҮҮВЭР СУДАЛГАА
2018 ОНЫ I УЛИРАЛ

4. ДҮГНЭЛТ

4.1. Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгааны дүгнэлт

Судалгааны үр дүнгээс харахад ирэх 12 сарын хугацаанд иргэдийн дунд инфляци өнөөдрийн түвшнээс өснө гэсэн хандлага давамгайлж байна. Иргэд 2019 оны I улиралд инфляцийг 6.0% /тоон хариултын хувьд/, 6.4% /мэдрэмжид суурилсан/, 10.2% /чанарын хариултын хувьд/ тус тус байхаар хүлээж байна.

Төгрөгийн ханш чангарна гэсэн иргэдийн хүлээлт 2017 оны дунд үеэс эхлэн огцом нэмэгдсэн бөгөөд 2018 оны 1 дүгээр улирлын судалгаагаар иргэд төгрөгийн гадаад валюттай харьцах ханш цаашид чангарна гэсэн хүлээлт хэвээр байна.

Иргэд ирэх нэг жилийн хугацаанд эдийн засгийн ерөнхий байдал сайжирч, улмаар өрхийн санхүүгийн байдалд эерэг нөлөө үзүүлнэ гэсэн хүлээлттэй байна.

4.2. Аж ахуй нэгжийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгааны дүгнэлт

ААН-ийн инфляцийн хүлээлтийн санал асуулгын дүнгээр ААН-үүд инфляци өнөөдрийн түвшинд хадгалагдана гэж үзэж байна. ААН-үүд 2019 оны I улиралд инфляцийг 5.1% /чанарын хариулт/, 5.9% /мэдрэмжид суурилсан/, 6.2% /тоон хариулт/ тус тус байхаар хүлээж байна.

ААН-ийн 73% нь 2019 оны I улиралд инфляцийн түвшинг зорилтот түвшинд буюу 8%-аас бага байна гэж хүлээж байна. Мөн инфляцийг 6-8 хувьд байна гэсэн хариулт хамгийн өндөр дамтамжтай байна.

Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн дийлэнх нь ирэх 12 сарын хугацаанд төгрөгийн ам.доллартай харьцах ханшийг чангарна гэж хүлээж байна.

Ирэх 6 сарын хугацаанд ААН-үүд нийт эрэлт нэмэгдэж, борлуулалтын орлого өснө гэж хүлээж байна. Улмаар тэдгээр бизнес эрхлэгчдийн багагүй хэсэг нь ирэх саруудад үйл ажиллагаагаа тэлэх орон зай үүсч байгаа гэж үзэхийн зэрэгцээ цалингийн түвшинг өсч, ажлын байрыг нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

4.3. Шинжээчдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгааны дүгнэлт

Санал асуулгын үр дүнгээс харахад шинжээчид инфляцийн түвшинг 2018 оны II улиралд 6.1%, харин 2018 оны эцэст 7.8%-д хүрнэ гэж хүлээж байна.

Харин төгрөгийн ам.доллартай харьцах ханшийг энэ оны эцэст 2,389 төгрөгт хүрнэ гэж үзсэн нь төгрөг ам.долларын эсрэг чангарна гэсэн хүлээлттэй байгааг илэрхийлж байна.


Ирэх 12 сарын хугацаанд мөнгөний бодлого зөөлөрч, улмаар зээлийн хүү өнөөгийн түвшнээс бага зэрэг буурч эдийн засгийн өсөлт нэмэгдэнэ гэсэн хүлээлт давамгайлж байна.




ХАВСРАЛТ 1.

Судалгаанд оролцсон нийт иргэдийн 57% нь эмэгтэй, 43% эрэгтэй бөгөөд насны байдлаар нь авч үзвэл 32% нь 18-25, 30% нь 26-35, 19% нь 36-45, 12% нь 46-55, 8% нь 56-аас дээш гэсэн насны ангилалд хамрагдаж байна. /Хавсралт 1-1, Хавсралт 1-2/

Хавсралт 1-1. Хүйс



Хавсралт 1-2. Нас




Мөн судалгаанд оролцогчидийн 42% нь бүрэн дунд, 51% нь дээд боловсролтой бөгөөд тэн хагас нь сард 700.000 төгрөгөөс их зардал гаргадаг байна.

Хавсралт 1-3. Боловсролын түвшин




Хавсралт 1-4. Сарын дундаж зардал



Эх сурвалж : Монголбанк,иргэдийн хүлээлтийн түүвэр судалгаа

Хавсралт 1-5. Түүвэр судалгаа авсан газарзүйн тархалт



**ХАВСРАЛТ 2.**

Судалгаанд хамрагдсан нийт 383 аж ахуй нэгж, байгууллагуудыг өмчлөлийн хэлбэрээр авч 153 (40%) нь хязгаарлагдмал хариуцлагатай компани, 162 (42%) нь бусад хэлбэрийн, 23 (6%) нь хувьцаат компани, 34 (9%) нь нөхөрлөл болон үлдсэн 11 (3%) нь өөр бусад төрлийн өмчлөлийн хэлбэртэй байгууллагууд байлаа (*Хавсралт 2-1*).

Хавсралт 2-1. Аж ахуй нэгжийн тоо /өмчлөлөөр/

Аж ахуйн нэгжийн хэлбэр	тоо	хувь
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	153	40%
Нөхөрлөл	34	9%
Хоршоо	10	3%
Хувьцаат компани	23	6%
Төрийн өмчит үйлдвэрийн газар	1	0%
Бусад	162	42%
НИЙТ ДҮН	383	100.0%

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн салбаруудаар ангилан авч үзвэл нийт 383 ААН-ээс үйлчилгээ эрхэлдэг 54%, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлдэг 23%, боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг 1% болон бусад төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг 14% байна (*Хавсралт 2-2*).

Хавсралт 2-2. Аж ахуй нэгжийн тоо /салбараар, ажилтны тоогоор/

Салбарын ангилал	Ажилчдын тоо /бүлгээр/					Бүгд
	< 10	11–19	20–49	50–100	101 <	
Хөдөө аж ахуй	1%	0%	0%	1%	1%	2%
Уул уурхай, олборлох	0%	0%	0%	0%	1%	1%
Боловсруулах үйлдвэр	0%	1%	0%	0%	0%	1%
Барилга	1%	0%	0%	0%	1%	2%
Б/Ж худалдаа	21%	1%	1%	0%	0%	23%
Үйлчилгээ	44%	3%	2%	2%	3%	54%
Тээвэр	1%	0%	0%	1%	1%	2%
Бусад	10%	1%	0%	1%	1%	14%
НИЙТ ДҮН	77.6%	5.9%	3.5%	4.9%	8.2%	100%

Эх сурвалж: Монголбанк, ААН-ийн хүлээлтийн түүвэр судалгаа

Судалгаанд хамрагдсан нийт 383 аж ахуй нэгж, байгууллагуудын дийлэнх буюу 77.6% нь 9 хүртэл ажилчинтай, 5.9% нь 10-19 ажилчинтай, 3.5% нь 20-49 ажилчинтай, үлдсэн 13% нь 50-с дээш ажилчинтай аж ахуй нэгжүүд хамрагджээ (*Хавсралт 2-2*).


Судалгаанд оролцогч ААН-үүдийн дийлэнх буюу 67% нь ирэх 6 сарын хугацаанд компанийнхаа үйл ажиллагааг өргөжүүлэх төлөвлөгөөгүй байна гэж хариулжээ. Харин бизнес эрхлэгчдийн 33% нь ирэх 6 сарын хугацаанд үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд үүний тулд ихэнх ААН банкны зээлээр (35%) болон өөрийн хөрөнгөөр (31%) санхүүжүүлнэ гэж хариулсан байна /*Хавсралт 2-3*/.

Хавсралт 2-3. Ирэх 6 сарын хугацаанд үйл ажиллагааг өргөжүүлэх эсэх


Санхүүжилтийн хэлбэр	Үйл ажиллагаагаа өргөжүүлэх үү?	
	Тийм	Үгүй
Банкны зээлээр	35%	
Компанийн өөрийн хөрөнгөөр	31%	
Хувьцаа гаргах	2%	
Гадаад эх үүсвэрээр	2%	
Бусад санхүүгийн байгууллагын эх үүсвэрээр	8%	
Тэтгэлэг, тусламжаар	2%	
Хувь хүнээс зээлэх	8%	
Бусад	12%	
НИЙТ ДҮН	33%	67%

Эх сурвалж: Монголбанк, ААН-ийн хүлээлтийн түүвэр судалгаа


Хавсралт 2-4. Түүвэр судалгаа авсан газарзүйн тархалт




Хавсралт 3-1. Инфляци /таамаглал, 2018 оны II улирал/




Хавсралт 3-2. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш /таамаглал, 2018 оны II улирал/



Хавсралт 3-3. Зээлийн хүү /таамаглал, 2018 оны II улирал/



Хавсралт 3-4. M2 мөнгөний өсөлт /таамаглал, 2018 оны эцэс/



Эх сурвалж: Монголбанк, шинжээчдийн хүлээлтийн түүвэр судалгаа